




ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



USAID
FROM THE AMERICAN PEOPLE

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн Сантай хамтран MICS Plus (ОУБТС+) судалгааг 2020 оны 9 сараас хэрэгжүүлж эхэлсэн. ОУБТС+ нь КОВИД-19 цар тахлын үед хүүхэд, гэр бүл, өрхийн нөхцөл байдлыг тодорхойлох өгөгдлийг бий болгож, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудад мэдээлнэ. Энэхүү хормын хувилбарт 2021 оны 7 сарын 1-ээс 22-ний хооронд дуудлага хийгдсэн 5-р шатны үр дүнг нэгтгэн харуулав.



Арга зүй, аргачлал

MICS Plus аргачлал нь түүврийн төлөөлөх чадвартай, өрхөд суурилсан статистик судалгааны давуу талыг компьютерийн тусламжтай утсаар ярилцлага авах (CATI) технологийн бодит цаг үеийн мэдээллийг үргэлжилсэн хугацаанд мэдээлэх давуу талтай хослуулсан. Мэдээлэл цуглуулах горим нь судлаач уламжлалт аргаар нүүр тулж ярилцах бус, харин хариулагчтай* шууд утсаар холбогдож мэдээлэл цуглуулах явдал юм.

ОУБТС+ судалгааны аргачлалыг дараах зүйлд үндэслэсэн:

- Өрх/өрхийн гишүүдийн утасны дугаарыг багтаасан өрхийн түүврийн хүрээнээс магадлалт түүврээр өрхийг сонгох
- Сонгогдсон өрх рүү урт хугацаанд шууд дуудлага хийж ярилцлага авах


Судалгааны түүврийг ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-аас авсан. 2020 оны 1-р сарын байдлаар бүртгэлд суурилсан Хүн ам, орон сууцны тооллогыг түүврийн хүрээ болгон ашигласан. Нийт түүврийн хэмжээ 2200 өрх

Хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор ХАӨМС-ын утасны дугаарыг баталгаажуулах, утасны дугаар байхгүй өрхүүдтэй орон нутгийн хэлтсээр дамжуулан холбогдож, хамгийн сүүлийн утасны дугаарыг олж авсан. ОУБТС+ судалгааны эхний шатанд хамрагдаагүй өрхүүдийг орлуулахын тулд загварт суурилсан орлуулах аргыг ашигласан ба дараагийн шатуудад орлуулалт хийгдээгүй.

ОУБТС+ нь үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий түүврийг ашигладаг. Хот, хөдөө нь түүврийн гол домайн бөгөөд түүврийг дараах байдлаар хуваарилсан. 4 бүс тус бүрээр 400 өрх, Улаанбаатар хотоос 600 өрх. Судалгааны бүх шатанд ижил өрхийг хамруулж, панел дата үүсгэнэ. Судалгааны 5-р шатанд өрхүүд цар тахлын үеэр КОВИД-19 халдвараас өөрийгөө хамгаалах дадал, КОВИД-19 халдвартай холбоотой санаа зовнил, шинжилгээнд хамрагдсан байдал болон вакцинжуулалт, өвсөр насныхны сайн сайхан байдал, эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт ба бохирдол, амьдралын сэтгэл ханамжийн талаар тодруулсан.

* Өрх бүрт дуудлага хийж судалгааг авахдаа “өрхийн талаар мэдлэгтэй, насанд хүрсэн өрхийн гишүүн”-тэй ярилцсан. Судалгаанд оролцогчдыг санамсаргүй байдлаар сонгоогүй тул, хариулагчийн өөрийн шинж чанар, үзэл бодол, зан үйлийн хэв маягт үндэслэсэн өгөгдөл нь Монгол улсын насанд хүрсэн нийт хүн амын төлөөлөл болж чадахгүй.

Түүврийн хэмжээ, бүсээр





Хураангуй

Өмнөх шаттай харьцуулахад хариулагчдын бараг ижил хувь нь олон нийтийн газар явахад зайлсхийж чаддаг бөгөөд ажилдаа явах, дэлгүүр орох зэрэг нь гол шалтгаан болж байна.

Дээгүүр аж байдалтай өрхийн хүн амын хувьд олон нийтийн газарт хүн хоорондын зай барих нь буурч байгаа бол хөдөөгийн хүн ам болон доогуур аж байдалтай өрхийн хүн амын хувьд энэ үзүүдэлт өсч байна. Амны хаалт зүүх нь бүх нийтийн хэрэглээ хэвээр байна. Судалгаанд хамрагдагсад гэр бүлийн хэн нэгэн гишүүн КОВИД-19-ын халдвар авч хүндээр өвчлөх вий, дараа сарын өрхийн санхүүдээ санаа зовниж буй хувь нэмэгдээр байна. Судалгаанд хамрагдсан арван хүний ес нь КОВИД-19 халдварын эсрэг вакцины ядаж нэг тунг хийлгэсэн байна.

Энэ шатанд өсвөр насныхны эрүүл мэнд болон сайн сайхан байдлын талаар судалсан ба судалгааны үр дүнгээс харахад 10-19 насны өсвөр насныхны 7 хувь дор хаяж нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй бөгөөд сэтгэл түгших байдал хамгийн өндөр тархалттай байна. Өсвөр насны арван хүүхэд тутмын дөрөв нь 4 ба түүнээс дээш цаг (хичээл хийсэн цагийг оруулаагүй) дэлгэцийн өмнө (зурагт, компьютер, гар утас, бусад электрон төхөөрөмж) өнгөрөөсөн байна.

Судалгаанд хариулагчдын талаас илүү нь дэлхийн дулаарлын талаар сонссон бөгөөд тэдний ихэнх нь дэлхийн дулаарал болж байна гэж үзсэн. Дэлхийн дулаарал болж байна гэж бодож байгаа эсвэл болж байгаа эсэхийг мэдэхгүй байгаа 10 хариулагчийн 8 нь дэлхийн дулааралд маш их болон зарим талаар санаа зож байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан 10 хариулагчийн 8 нь дэлхийн дулаарал хойш үеийнхэн, ургамал амьтны төрөл зүйлд ихээхэн хор хөнөөл учруулна гэж үзсэн бол 6 нь Монгол Улсын иргэдэд хор хөнөөл учруулна гэж үзжээ. Судалгаанд хамрагдагсдын үзэж байгаагаар дэлхийн дулааралт хамгийн өртөмтгий бүлэг нь хүүхэд, малчид, ахмад настнууд байна. 10 хариулагчийн 9 нь оршин суугаа нутагт нь дор хаяж нэг бохирдол (агаар, хөрс, усны бохирдол) байгаа гэж үзсэн бөгөөд хот, хөдөөгөөр ялгаа их байна.

Энэ шатанд, судалгаанд хариулагчдаас сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан гэж үзсэн, ирэх жилд амьдралаа сайжирна гэж бодож байгаа талаар асуусан. Судалгаанд хамрагдсан 10 хүний зөвхөн 1 нь сүүлийн 1 жилд амьдрал сайжирсан гэж хариулсан бол 4 нь ирэх жилд амьдрал сайжирна гэж үзсэн байна.



Судалгааны хэрэгжилт


Хамрагдалтын хувь



Нийт түүврийн зорилтот хэмжээ 2200 өрх гэж тогтоосон бөгөөд 1-р шатанд 344 өрхийг “Ойролцоо хөрш” загварт суурилсан аргаар онцлог шинжийг ашиглан орлуулсны дараа хамрагдалтын түвшин 97 хувь болсон. Дараагийн шатуудад эхний шатанд татгалзсан, дуудлагад хариулагч нь сонгогдсон өрхөд амьдардаггүй, сонгогдсон өрх холбоо барих утасгүй, хаяг дээр өрхгүй тохиолдлуудыг хасч 2,154 өрхийг судалгаанд хамруулахыг зорьсон. 5-р шатны хамрагдалт 87 хувь буюу хамрагдалт өндөр хэвээр байна. 1-р шатнаас хойш орлуулалт хийгдээгүй.

Ярилцлагын хугацаа


Ярилцлагын медиан хугацаа, хот, хөдөөгөөр



Ярилцлагын үеэр тасалдсан, мэдээлэл зөрүүтэй байсны улмаас 1-р шатанд 191 өрх, 2-р шатанд 203 өрх, 3-р шатанд 316, 4-р шатанд 200 өрх, 5-р шатанд 72 өрхийн ярилцлагыг ярилцлагын дундаж болон медиан хугацаа тооцоход оруулаагүй

Дундаж дуудлага хийх оролдлого

Бүрэн авсан ярилцлагын дуудлага хийх оролдлогын дундаж тоо, хот, хөдөөгөөр





КОВИД-19

КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: олон нийтийн газар очихоос зайлсхийх

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй хариулагчийн хувь, 3, 4 болон 5-р шат

Олон нийтийн газар очихоос зайлсхийж огт чадаагүй болон цөөн тохиолдолд чадсан хариулагчийн хувь, олон нийтийн газарт очсон тэргүүдэх шалтгаанаар, 3, 4 болон 5-р шат

■ 3-р шат ■ 4-р шат ■ 5-р шат





Тэмдэглэл: Олон нийтийн газар очсон шалтгааны талаар асуулт нь олон сонголтой байсан

КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: олон нийтийн газарт зай барих

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, ихэвчлэн болон байнга зай бариж чаддаг хариулагчийн хувь, 3, 4 болон 5-р шат

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, олон нийтийн газраар явахдаа ихэвчлэн болон байнга зай барьж чадсан хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар, 3, 4 болон 5-р шат

■ 3-р шат ■ 4-р шат ■ 5-р шат





КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: олон нийтийн газарт амны хаалт зүүх

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, олон нийтийн газраар явахдаа ихэвчлэн болон байнга маск зүүж байсан хариулагчийн хувь, 3, 4 болон 5-р шат

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, олон нийтийн газраар явахдаа ихэвчлэн болон байнга маск зүүж байсан хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар, 3, 4 болон 5-р шат

■ 3-р шат ■ 4-р шат ■ 5-р шат






КОВИД-19

КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: гараа угаах болон ариутгах

Сүүлийн 7 хоногт гараа ихэвчлэн болон байнга угааж/ариутгаж байсан хариулагчийн хувь, 3, 4 болон 5-р шат




Сүүлийн 7 хоногт гараа ихэвчлэн болон байнга угааж/ариутгаж байсан хариулагчийн хувь, өрхийн аж байдлын түвшингээр, 3, 4 болон 5-р шат



КОВИД-19 халдвартай холбоотой санаа зовж буй байдал

Ойр дотны хүн КОВИД-19 тусаж хүндээр өвчлөх вий гэдэгт санаа зовж буй хариулагчийн хувь, 3, 4 болон 5-р шат




Ирэх сарын өрхийн санхүүдээ санаа зовж буй хариулагчийн хувь, 3, 4 болон 5-р шат




КОВИД-19 халдвар илрүүлэх шинжилгээ

Коронавирус илрүүлэх шинжилгээ өгсөн хариулагчийн хувь, 4 болон 5-р шат



Коронавирус илрүүлэх шинжилгээ өгсөн хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар, 4 болон 5-р шат







КОВИД-19

КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт

КОВИД-19-ийн эсрэг вакцины ядаж нэг тунг хийлгэсэн хариулагчийн хувь, 4 болон 5-р шат




КОВИД-19-ийн эсрэг вакцины ядаж нэг тунг хийлгэсэн хариулагчийн хувь, вакцинаар



Тэмдэглэл: Бүх хариулагчид (4-өөс бусад) 18 ба түүнээс дээш насныхан байв

КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт – 2 дахь тун

КОВИД-19-ийн эсрэг вакцины эхний тунг хийлгэсэн боловч 2 дахь тунг хийлгээгүй хариулагчийн хувь, 5-р шат




КОВИД-19-ийн эсрэг вакцины 2 дахь тунг хийлгээгүй хариулагчийн хувь, шалтгаанаар, 5-р шат



КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт – гаж нөлөө

КОВИД-19-ийн эсрэг вакцины ядаж эхний тунг хийлгэсэн, ямар нэг гаж нөлөө илэрсэн хариулагчийн хувь, 5-р шат



КОВИД-19-ийн эсрэг вакцины ядаж эхний тунг хийлгэсэн, ямар нэг гаж нөлөө илэрсэн хариулагчийн хувь, илэрсэн тэргүүдэх 5 гаж нөлөөгөөр, 5-р шат




Тэмдэглэл: Гаж нөлөөний талаарх асуулт нь олон сонголттой байсан



Өсвөр насныхны сайн сайхан байдал ба эрүүл мэнд

Өсвөр насныхны үйлдлийн чадварын хүндрэл

Дор хаяж нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 10-19 насны өсвөр насныхны хувь



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бол нийгмийн хамгийн гадуурхагдсан бүлэгт багтдаг. Сөрөг хандлага хэлбэрээр өдөр бүр ялгаварлан гадуурхахтай тулгарах, зохих бодлого, хууль тогтоомж байхгүйгээс тэд ихэвчлэн хүн амын хамгийн ядуу хүмүүсийн тоонд ордог бөгөөд сургуульд явах, эмнэлгийн үйлчилгээ авах, нийгэмд дуу хоолойгоо хүргэх боломж багатай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах, гадуурхах нь тэднийг бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэл эсвэл үл тоомсорлох, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх өндөр эрсдэлтэй болгодог.

Хүүхдийн эрхийн тухай конвенц (НҮБХС, 1989) болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (НҮБ, 2006)-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг бусад хүүхдүүдтэй адил тэгш заасан байдаг бөгөөд үйлчилгээний хүртээмж, амьдралын бүхий л салбарт тэдний оролцоог сайжруулахыг уриалсан байдаг.

Эдгээр зорилгод хүрэхийн тулд үндэстэн дамнасан харьцуулж болохуйц, найдвартай мэдээлэл хэрэгтэй. Хүүхдийн үйлдлийн чадварын модуль нь ДЭМБ-ын Олон улсын үйлдлийн чадвар, хагжлийн бэрхшээлийн ангилал, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид нийцүүлэн хүүхдийн сонголт, хараа, харилцаа холбоо, ойлголт, суралцах, хөдөлгөөн, сэтгэл хөдлөл зэрэг янз бүрийн хэлбэрээр тулгарч буй үйлдлийн чадварын хүндрэлийн талаар мэдээлэл цуглуулах зорилготой. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүд амьдрах тааламжгүй орчинд оролцоо хязгаарлагдмал, тэдний эрхийн биелэлтийг хязгаарлах эрсдэлтэй байж болно.

Өсвөр насныхны үйлдлийн чадвар, хүндрэлийн хэлбэрээр


Үйлдлийн чадварын хүндрэлтэй 10-19 насны өсвөр насныхны хувь, хүндрэлийн хэлбэрээр

	Харах	Сонсох	Алхах	Өөрийгөө арчлах	Харилцах	Сурах	Ой тогтоолт	Анхаарал төвлөрөх	Өөрчлөлтийг хүлээн авах	Үйл хөдлөлөө хянах	Найзтай болох	Түгших	Сэтгэлээр унах
Нийт	0.6	0.7	1.6	0.7	0.2	0.9	0.1	0.4	0.5	0.1	0.5	3.3	1.7
10-14	0.4	0.1	0.8	0.1	0.0	0.1	0.1	0.4	0.6	0.0	0.1	4.2	1.6
15-19	0.9	1.5	2.7	1.5	0.5	2.0	0.1	0.4	0.4	0.2	1.0	2.1	2.0

Өсвөр насныхны үйлдлийн чадварын ялгаатай Туслах хэрэгсэл ашигладаг өсвөр насныхны байдал

Үйлдлийн чадварын хүндрэлтэй 10-19 насны өсвөр насныхны хувь, сонгосон шинж байдлаар

Үйлдлийн чадварын бэрхшээлд зориулсан туслах хэрэгсэл ашигладаг 10-19 насны өсвөр насныхны хувь







Өсвөр насныхны сайн сайхан байдал ба эрүүл мэнд

Биеийн жингийн өөрчлөлт

10-19 насны өсвөр насныхны хувь, 2020 оны 11-р сараас 2021 оны 7 сар хүртэл биеийн жин өөрчлөгдсөн эсэхээр (хариулагчийн мэдээлснээр)




2020 оны 11-р сараас 2021 оны 7 сар хүртэл биеийн жин өөрчлөгдсөн 10-19 насны өсвөр насныхны хувь (хариулагчийн мэдээлснээр), сонгосон шинж байдлаар




Биеийн жингийн өөрчлөлт

2020 оны 11-р сараас 2021 оны 7 сар хүртэл биеийн жин өөрчлөгдсөн 10-19 насны өсвөр насныхны хувь, хэрхэн өөрчлөгдсөнөөр (хариулагчийн мэдээлснээр)




2020 оны 11-р сараас 2021 оны 7 сар хүртэл биеийн жин нэмсэн 10-19 насны өсвөр насныхны биеийн жин өөрчлөгдсөнд санаа зовж буй эсэхээрх хариулагчийн хувь




Дэлгэц харахад зарцуулсан хугацаа

10-19 насны өсвөр насныхны дэлгэцийн өмнө (зурагт, компьютер, гар утас болон бусад электрон төхөөрөмж) цагаа өнгөрөөж байгаа хувь, дэлгэцийн өмнө өнгөрүүлсэн дундаж хугацаагаар



10-19 насны, ухаалаг утас, ТВ, компьютер зэрэг дэлгэц харж өнгөрүүлж байгаа өсвөр насны хүүхдийг дэлгэц харж өнгөрүүлж байгаа хугацаанд нь санаа зовж буй хариулагчийн хувь




Санаа зовж байна, хэтэрхий



Уур амьсгалын өөрчлөлт ба бохирдол

Дэлхийн дулаарал: мэдлэг

Дэлхийн дулаарлын талаар сонссон эсэх, хэрэв тийм бол дэлхийн дулаарал болж байгаа гэж бодож байгаа талаарх хариулагчийн хувь



Дэлхийн дулаарал: Санаа зовж буй байдал

Дэлхийн дулаарлын талаар сонссон, дэлхийн дулаарал болж байна гэж бодож байгаа эсвэл болж байгаа эсэхийг мэдэхгүй байгаа хариулагчийн хувь, дэлхийн дулааралд хэр их санаа зовж байгаагаар




Дэлхийн дулаарал: нөлөөлөл

Дэлхийн дулаарлын талаар сонссон, дэлхийн дулаарал болж байна гэж бодож байгаа эсвэл болж байгаа эсэхийг мэдэхгүй байгаа хариулагчийн хувь, дэлхийн дулаарал маш их хор нөлөө үзүүлнэ гэж бодож байгаа хувиар:


Хойш үеийнхэнд



Ургамал, амьтны аймагт



Монгол Улсын иргэдэд




Дэлхийн дулаарал: эмзэг бүлгийнхэн

Дэлхийн дулаарлын талаар сонссон, дэлхийн дулаарал болж байна гэж бодож байгаа эсвэл болж байгаа эсэхийг мэдэхгүй байгаа хариулагчийн хувь, дэлхийн дулаарал аль бүлэгт хамгийн их хор нөлөөтэйгөөр



Дэлхийн дулаарал: хэлэлцэх сэдэв

Дэлхийн дулаарлын талаар сонссон хариулагчийн хувь, дэлхийн дулаарлын талаар гэр бүл, найз нөхөдтэйгөө ярилцдаг эсэхээр





Уур амьсгалын өөрчлөлт ба бохирдол

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах бодлогыг дэмжих

Дэлхийн дулаарлын талаар сонссон, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах бодлогыг бүрэн болон тодорхой хэмжээгээр дэмжсэн хариулагчийн хувь, бодлогоор

Танай өрхийн цахилгааны зардал ойролцоогоор сард 10,000 төгрөгөөр нэмэгдсэн ч гэсэн цаг уурт ээлтэй цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх.



Цахилгаан станцуудад нүүрс хүчлийн хийн ялгаруулалтаа бууруулах хугацааг хатуу тогтоох мөн/эсвэл сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний үр ашигтай зарцуулалтад хөрөнгө оруулах.



Дэлхийн дулаарлыг бууруулах, нийтийн эрүүл мэндийг сайжруулахын тулд нүүрс түлдэг эрчим хүчний станцуудад ялгаруулах нүүрс хүчлийн хийн хатуу хязгаарыг тогтоох.



Нар болон салхины эрчим хүч гэх мэт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн суурилуулалт / дэд бүтцэд илүү хөрөнгө оруулах.




Нарын болон салхины эрчим хүч гэх мэт сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хийгдэх илүү олон судалгаа шинжилгээнд хөрөнгө оруулах.



Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн орон нутагт гарсан өөрчлөлтүүд


Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан орон нутагт нь өөрчлөлт гарсан, гарсан өөрчлөлтийг анзаарсан, дэлхийн дулаарлын талаар сонссон хариулагчийн хувь



Тэмдэглэл: Зөвхөн 5 хувиас дээш давтамжтай өөрчлөлтүүдийг харуулав


Орон нутгийн бохирдол

Оршин суугаа нутагт нь агаарын бохирдол, хөрсний бохирдол, усны бохирдол байна гэж үзсэн хариулагчийн хувь



Орон нутгийн бохирдол: Ялгаатай байдал

Орон нутагт нь дор хаяж нэг бохирдол байна гэж үзсэн хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар






Амьдралын сэтгэл ханамж

Амьдралын сэтгэл ханамж


Хариулагчийн хувь, амьдралын сэтгэл ханамж, амьдралын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээгээр




Тэмдэглэл: Доороосоо дээшээ гишгүүрүүд нь 0-10 хүртэл дугаарлагдсан шат байгаагаар төсөөлүүдэд судалгааны үед амьдралын сэтгэл ханамжийн түвшингээ аль шатан дээр зогсож байгааг мэдэрч байгаагаар харуулав

Илүү сайхан амьдралын тухай ойлголт


Сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан гэж үзсэн бөгөөд ирэх жилд амьдралаа сайжирна гэж үзсэн хариулагчийн хувь



Аз жаргалтай эсвэл маш их аз жаргалтай амьдарч байгаа хариулагчийн хувь, шинж байдлаар



Ирэх жилд амьдралаа сайжирна гэж үзсэн хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар



– Улсын дүн

ОУБТС+ судалгааны үр дүнгийн дашбоард болон илүү их мэдээллийг дараах хаягаар үзэх боломжтой:

НУБ-ын Хүүхдийн Сангийн MICS Plus олон улсын цахим хуудас <https://mics.unicef.org/mics-plus/mics-plus-results#mongolia>

Монгол Улсын УСХ-ны мэдээллийн цахим хуудас <https://www.1212.mn/survey.mn.aspx>

Үндэсний Статистикийн Хороо

Хаяг: Засгийн газрын III байр, Бага тойруу – 44 Улаанбаатар – 11, Монгол Улс

Утас: (+976) 11-326414

Лавлах утас: 1900-1212

Факс: (+976) 11-324518

Цахим хуудас: www.nso.mn

Цахим шуудан: information@nso.mn

Биднийг дагаарай

Facebook | @StatisticMongolia

Twitter | @Statistic_nso

НУБ-ын Хүүхдийн Сан Монгол дахь оффис

Хаяг: НУБ-ын Нэгдсэн байр, Нэгдсэн Үндэстний гудамж-14, Улаанбаатар 14201, Монгол Улс

Утас: (+976) 11-312217

(+976) 11-312185

Цахим хуудас: www.unicef.org/mongolia

Цахим шуудан: ulaanbaatar@unicef.org

Биднийг дагаарай

Facebook | @unicef_mongolia

Twitter | @UNICEF_Mongolia